

УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ **Нэг. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ**

1972 онд арьс ширний үйлдвэрийн нэгдлийн харьяанд арьс шир боловсруулах үйлдвэрүүдээс хоногт 10.000м^3 - 13.000м^3 технологийн хаягдал усыг хүлээн авч механик цэвэрлэгээ хийх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн.

1975 онд өргөтгөл хийгдсэн ба 1993 онд цэвэрлэх байгууламж нь хувьчлагдаж “Харгиа” нэртэй хувьцаат компани болжээ.

Арьс шир үйлдвэрлэлийн салбар уналтад орж, түүхий эдийг боловсруулахгүйгээр экспортлож байсан 1990-2000 оны үед “Харгиа” цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон. Өөрөөр хэлбэл уг цэвэрлэх байгууламжид техник, технологийн ямар ч шинэчлэл хийгдээгүй 30 гаруй жил болсон учир шугам хоолой, тоног төхөөрөмжүүд нь элэгдэлд орж хуучран технологийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүй болж, зөвхөн механик цэвэрлэгээ хийн бохир усыг нийлүүлснээс Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг доголдуулж, цэвэрлэгээний түвшинг бууруулж, байгаль орчинд ноцтой хохирол учруулсаар байв.

Эдгээр нөхцөл байдлын талаар МУ-ын ЗГ-ын 2008 оны 07-р сарын 09-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн /42-р тэмдэглэл/ юм. Мөн ЗГ-ын 2009 оны 10-р сарын 14-ний өдрийн 63-р тогтоол гарч, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийг шинээр барих техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, “Харгиа” ХК-ийн урьдчилан цэвэрлэх байгууламжийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэж, ЗГ-т танилцуулахыг Нийслэлийн засаг дарга бөгөөд УБ хотын захирагч, БХБ-ын сайд, ҮХ-ын сайд нарт үүрэг болгосон. Дээрх тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн засаг даргын 2009 оны 07-р сарын 02-ны өдрийн 340 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг МАШҮХолбоо, “Харгиа” ХК-ийн удирдлагуудыг оролцуулан 7 удаа хуралдаж, асуудлын авч хэлэлцсэн байна.

Хувьцаа эзэмшигчид нь хөрөнгө оруулалт хийж, цаашид тасралтгүй үйл ажиллагааг нь ханган ажиллуулж чадахгүй болсон тухай санал, хромын гурван валенттай химийн нэгдэлтэй технологийн хаягдал усыг цэвэршүүлэх байгууламж

төрийн мэдэлд байдаг онцгой объект мөн болно гэсэн ажлын хэсгийн дүгнэлт зэргийг үндэслэн, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 12-р сарын 22-ны өдрийн 180 дугаар тогтоол гарч, ямар нэгэн төлбөр тооцоо хийхгүйгээр “Харгиа” цэвэрлэх байгууламжийн барилга, үндсэн тоног төхөөрөмжүүдийг нийслэл өмчлөлдөө шилжүүлэн авч “Урьдчилан цэвэрлэх байгууламж” НӨҮГазрыг байгуулсан.

Гэвч 2013 оны 03-р сарын 15-ны өдөр хийгдсэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагуудын хамтарсан шалгалтаар тус байгууламжийн зохион байгуулалт, менежментийг өөрчлөх шаардлагатай мөн УСУГ-ын харьяа Төв цэвэрлэх байгууламжтай нэг бүтэц орон тоонд оруулж ажиллуулах нь зөв гэж үзсэн билээ.

Улмаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 08-р сарын 16-ны өдрийн 89 дүгээр тогтоол гарч “Урьдчилан цэвэрлэх байгууламж” НӨҮГ-ыг татан буулгаж, чиг үүрэг, үйл ажиллагаа, хөрөнгийг “Ус сувгийн удирдах газар” НӨҮГ-т шилжүүлэхээр болсон.

Хоёр. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Тус байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт нь 2010 оны 04-р сарын 06-ний өдрөөс эхэлсэн боловч орон тоонд нь архивын ажилтан байхгүй ба хүний нөөцийн ажилтан Д.Амгалан нь тус ажлыг хавсран гүйцэтгэж байсан болно.

2013 оны 03-р сарын 17-ны өдрөөс П.Энхмандахыг Архив, бичиг хэргийн ажилтнаар томилогдон ажилласан.

Тус газрыг татан буулгахтай холбогдуулан НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 08-р сарын 16-ны өдрийн 89 дүгээр тогтоолд тус байгууллагын архивын бичиг баримтыг төрийн архивт шилжүүлэн өгөхийг үүрэг болгосон юм.

Үүрэг болгосоны дагуу Төрийн архивт баримтаа шилжүүлэхээр архивын баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын дараах ажлыг хийлээ. Үүнд:

- Байгууллагын архивлалт огт хийгдээгүй байсан ба баримт бичгүүд нь маш эмх замбараагүй, бүртгэл огт хийгдээгүй байсан болно.
- Ажилтан ажлаа хүлээлгэн өгөх хүлээн авахад баримт бичиг хүлээлцсэн акт огт хийгдээгүй байсан байна.

- Байгууллагын бүх баримт бичгийг ангилан ялгаж шинээр 00 хн-ийг үүсгэсэн.
- Ирсэн, явуулсан албан бичиг бүрийг нягтлан шалгаж байнга хадгалах болон түр хадгалахаар ангилан ялгасан.
- Даргын болон боловсон хүчний гаргасан тушаалууд нь нэг дугаарлалтаар явж байсныг ангилан ялгалт хийж хугацааны дараалалд оруулж дутуу байсан тушаалыг бусад баримтан дотроос нөхөн илрүүлж байнга хадгалах бүртгэл үйлдсэн.
- Санхүүгийн тайлан балансуудыг хадгалах хугацаагаар нь ялган үдсэн.

Байгууллагад хадгалагдаж байсан 2010-2013 оны бүх баримт бичгүүдийг ангилан ялгаж байнгад хадгалах 40 хадгаламжийн нэгж, 70 жилийн хугацаатай хадгалах 13 хадгаламжийн нэгж, түр хадгалах 55 хадгаламжийн нэгжийг тус тус шинээр үүсгэлээ.

Мөн зарим байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй хэрэглэгдэх техникийн болон инженерийн зураг бүхий 10 хадгаламжийн 523 хуудас баримт бичигт бүртгэл хийж УСУГ-ын техникийн архивт хүлээлгэн өгөх баримт үйлдэн хүлээлгэн өгч хүлээлгэн өгсөн баримтыг хавсаргалаа.